МЭДЭЭ · 2022 оны 2-р сарын 9

ХОРИХ АНГИУДЫН УДИРДЛАГА, БИЕ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Дархан-Уул аймгийн прокурорын газраас 2022 оны 1 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 435 дугаар хаалттай хорих анги, 445 дугаар нээлттэй хорих ангиудын үйл ажиллагаа, ахуй нөхцөлтэй танилцаж, хорих ангиудын удирдлага, бие бүрэлдэхүүнтэй уулзалт зохион байгуулжээ.

Уулзалтын үеэр прокуророос ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ажлын чиглэлээр 2022 онд авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг танилцуулж, хорих ял эдлүүлэх ажиллагаанд хууль, журам, зааврыг нэг мөр хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг, чиглэл өгчээ.

Түүнчлэн "Эрүүдэн шүүхийн тухай ойлголт, хохирол, хор уршиг, эрүүгийн хариуцлага" сэдвээр сургалт хийж, санал солилцсон байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2343